



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тайшир сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2023/107/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Н.Гэрэлмаа Утас: 99782918 Цахим хаяг: gerelmaan@audit.gov.mn Аудитор: Б.Мөнхболд Утас: 99041008 Цахим хаяг: munkhboldbo@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 109

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тайшир сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Тайшир сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж, Засаг даргын нөөц хөрөнгөөс байгууллага, иргэдэд сургалтын дэмжлэг, урлаг, спортын шагнал олгосон, цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, тээвэр шатахууны зардлын худалдан авах ажиллагаа зарлаагүй шууд худалдан авалт хийсэн, хөрөнгийн тооллого хийгээгүй, өмнөх шийдвэрийг хэрэгжүүлээгүй, авлага, өглөгийн тооцоо нийлээгүй, нярвын тайлан, шатахууны зарцуулалт тодорхой бус, жолоочийн замын хуудсаар тооцоо бодолгүйгээр шатахууныг зарцуулсан, шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн оруулаагүй зэрэг 29,583.2 мянган төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.4, 16.5.5, 22 дугаар зүйлийн 22.1, 41 дүгээр зүйлийн 41.12.2, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалттай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмаар шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг олгох бүрэн эрхийг Засаг даргад олгосон боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулиар дээрх арга хэмжээний зардлыг зарцуулахыг хориглосон байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд төсвийн 14,525.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, үнэ төлбөргүйгээр 114,569.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлого авсан байна.

0702700350

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 4 хөтөлбөр, 16 зорилт, 136 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж биелэлтийн тайланг хүргүүлснээс сумын Засаг даргаас нийт дүнгээр 80.1 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Нэг. Аудитын санал дүгнэлт

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мянган. төгрөг/

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	158,257.1	209,870.3
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,386,308.3	1,316,211.3
Нийт хөрөнгийн дүн	1,544,565.4	1,526,081.6
Нийт өр төлбөрийн дүн	204.6	-
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,544,360.8	1,526,081.6
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,544,565.4	1,526,081.6
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	736,081.0	761,745.1
Үйл ажиллагааны зардлын дүн	519,710.3	780,024.3
Үйл ажиллагааны үр дүн	216,370.6	(18,279.2)
Үйл ажиллагааны бус үр дүн		
Үйл ажиллагааны нийт үр дүн	216,370.6	(18,279.2)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,327,990.1	1,544,360.8
Тайлант оны үр дүн	216,370.6	(18,279.2)
Эцсийн үлдэгдэл	1,544,360.8	1,526,081.6
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	371,725.1	631,248.1
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	371,725.1	616,723.1
Үйл ажиллагааны ЦМГ	-	14,525.0
Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	(14,525.0)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	0.0	0.0
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0.0	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан УТ		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	0.0	0.0
Урсгал зардал	0.0	0.0
Хөрөнгийн зардал	0.0	0.0
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	0.0	0.0
Улсын төсвөөс санхүүжих	0.0	0.0
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	740.0	250.0
Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	0.0	0.0
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	346,230.8	531,152.6
Урсгал зардал	346,230.8	531,152.6
Хөрөнгийн зардал	0.0	0.0
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	346,230.8	562,953.9
Орон нутгийн төсвөөс санхүүжих	345,490.8	562,703.9
Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	0.0	0.0

Гурав. Аудитын илрүүлэлт:

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар 89.4 сая төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Санхүү үр дүнгийн тайланд нэмэлт санхүүжилтийн орлого 66.0 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих гэж буруу тайлагнасан.
- Бараа материалын тодруулга тайланд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 1.0 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлэн авснаар тайлагнасан.
- Санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлыг 5.3 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.
- Мөнгөн гүйлгээний тайлан 17.1 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан зэрэг нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэж заасныг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 29.5 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 29.5 сая төгрөгийн 4 зөрчил² илэрч зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх талаар 4 албан шаардлага өгсөн.

5.1 Албан шаардлага

1. Жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийгээгүй, өмнөх шийдвэрийг хэрэгжүүлээгүй нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13-т "албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтын 19 дүгээр зүйлийн 19.2-т "Шалгадагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тооллогыг хууль журмын дагуу хийх албан шаардлага хүргүүлсэн.

2. Ажилчдын цалингаас суутгасан ХХОАТ-ыг 0.5 сая төгрөгөөр дутуу төлсөн бөгөөд Хувь хүний орлогын албан татварын авлага, өглөгийн тооцоо нийлээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах;" 20 дугаар зүйлийн 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-т "ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өглөг, авлагын тооцоог нийлж барагдуулах албан шаардлага хүргүүлсэн.

3. Няравын тайлан, шатахууны зарцуулалт тодорхой бус, жолоочийн замын хуудсаар тооцоо бодолгүйгээр 25.4 сая төгрөгийн шатахууныг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийг хууль журмын дагуу хөтөлж, зарцуулах албан шаардлага хүргүүлсэн.

4. Засаг даргын нөөц хөрөнгөөс байгууллага, иргэдэд 3.6 сая төгрөгийн сургалтын дэмжлэг, урлаг, спортын шагнал зэргийг олгож үр дүнгүй зардал гаргасан нь "Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох"; 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар зарцуулах албан шаардлага хүргүүлсэн.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайшир сумын Засаг даргын Тамгын газар	1	66.0	-	-	1	66.0	1	66.0	-	-	-	-
	1	5.3	-	-	1	5.3	1	5.3	-	-	-	-
	1	1.0			1	1.0	1	1.0				
	1	17.1	-	-	1	17.1	1	17.1	-	-	-	-
Дүн	4	89.4	-	-	4	89.4	4	89.4	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
Тайшир сумын Засаг даргын Тамгын газар	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-
	1	0.5	-	-	1	0.5	-	-	-	-	-	-
	1	25.4	-	-	1	25.4	-	-	-	-	-	-
	1	3.6	-	-	1	3.6	-	-	-	-	-	-
Дүн	4	29.5	-	-	4	29.6	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Тайшир сумын Засаг даргын Тамгын газар	1	14.5	-	-	1	14.5	-	-
	1	-	-	-	1	-	-	-
	1	23.0			1	23.0		
Нийт дүн	3	37.5	-	-	3	37.5	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1	-	-	-	1	-	-
	НИЙТ	1	1	-	-	-	1	-	-

